

БАТЛАВ.

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ц.НЯМДОРЖ

“ТӨРИЙН ЦАХИМ ХАРИЛЦААНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

УИХ-аас 2016 онд баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн Дэд бүтцийн салбарын 7 дугаар зорилт, 2010 онд баталсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.2.2.-3.6.2.4., 3.6.3.3., 3.6.3.6., 3.6.4.1., 3.6.4.3., 3.6.4.4. заалт, 2017 онд баталсан “Төрийн албаны тухай хууль”-ийн 37.1.12 дахь заалт, УИХ-ын 2011 оны 61 дүгээр тогтоолын 2 дахь заалт, Засгийн газрын 2017 онд 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” үндэсний хөтөлбөрийн 3.9.2., 3.9.3., 3.9.4. 3.9.5., 3.9.9.–д төрийн цахим харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тус тус заасан.

Төрийн мэдээллийг ашиглах харилцааг “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай” хуулиар зохицуулж байгаа боловч уг хуулийн зохицуулалт нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийг ил тод байлгах, тэдгээр мэдээллийг вэб сайтдаа нийтлэх харилцаагаар, Шилэн дансны тухай хуулиар төрийн байгууллагуудын төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, тэдгээртэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байх харилцаагаар тус тус хязгаарлагдаж байна. Түүнчлэн, Монгол Улсын хэмжээнд өнөөгийн байдлаар мэдээ, мэдээлэл, мэдээллийн сан, цахим системтэй холбоотой зохицуулалт 154 хуулинд тусгагдсан бөгөөд тэдгээрийн зонхилох хэсэг нь мэдээлэл, мэдээллийн санг үүсгэх, бүрдүүлэх харилцааг зохицуулж байгаа ба тэдгээр мэдээлэл, мэдээллийн санд хандах, ашиглах, үнэлэх, үнэ цэнэтэй болгох харилцааг хууль зүйн түвшинд зохицуулсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор баталсан цахим хэлбэрээр үзүүлж болох 496 үйлчилгээний 320 буюу 64 хувь нь төрийн бусад байгууллагаас мэдээлэл авах үйлчилгээ байгаа бол Нийслэлийн засаг даргын тамгийн газраас 2013 онд явуулсан "Төрийн үйлчилгээг онлайн болгох техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах" зөвлөх үйлчилгээний судалгаагаар төрийн нийт үйлчилгээний 55.5 хувь нь бусад байгууллагад байгаа мэдээлэл авч ирэх шаардлага тавьж байгаа нь төрийн байгууллагууд мэдээллээ технологийн тусламжтай харилцан солилцдог хэлбэрт шилжих шаардлагатайг харуулж байгаагаас гадна төр өөрт байгаа мэдээллийг иргэнээс нэхэж байгаа зохисгүй хандлага олон жил хадгалагдсаар ирсэн.

Монгол Улсын Засгийн газраас төрийн цахим харилцаа, цахим засгийг хөгжүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд тодорхой шийдвэрүүд гаргаж томоохон хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд төрийн байгууллагууд өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй технологийн тусламжтайгаар, үр ашигтай харилцах, үйлчилгээгээ хүргэх цахим орчны дэд бүтэц, техник, технологийн үндэс суурь, дундын нөөцийг бүрдүүлээд байгаа ба энэхүү шинэ орчинд төрийн байгууллагуудын жигд, тэгш оролцоо, тэдгээрийн харилцан уялдаатай ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлага практикаас урган гарч байна.

Монгол Улсад интернэтийн үйлчилгээ 1996 онд, интернэт банкны үйлчилгээ 2002 онд тус тус нэвтэрснээс гадна төрийн болон бизнесийн олон үйлчилгээ онлайн, цахим хэлбэрээр хийгдэх болсноос гадна 2019 оны жилийн эцсийн байдлаар гар утас хэрэглэгчдийн тоо 4.36 сая, түүний дотор ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 3.1 саяд хүрч, үүрэн холбооны 4 дүгээр үеийн технологи нийт 360 гаруй сум, суурин газруудыг хамраад байгаа нь иргэдийн зүгээс төрийн үйлчилгээг хүндрэл, зардал багатайгаар орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах эрэлт, хүсэлтийг бий болгож байна.

Төрийн мэдээлэлд хандах, түүнийг дахин ашиглах, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон аж ахуйн байгууллагуудын хооронд харилцан мэдээлэл солилцох, нээлттэй өгөгдөл бий болгож эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүчин зүйл болгох, үнэ цэнийг өсгөх, олон талт бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр бий болж хөгжих боломжийг нээх шаардлага мэдээллийн технологийн салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, дэлхий нийтийн хандлагын дагуу урган гарч байна.

Захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны цахимжилт эрчимжиж, технологи нэвтрүүлэх ажил ахицтай байгаа ч хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн уялдаа сул, мэдээллийн технологийн сонголт, санхүүжилтийн үр ашигийн үнэлгээ, дүгнэлт, нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдэхгүй байгаа нь хууль, эрх зүйн орчин дутагдагдалтай байгаатай холбоотой байна.

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Үүсээд байгаа асуудлын шийдвэрлэлтийн цар хүрээнд нийцүүлэн төрийн цахим харилцааны анхдагч хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана:

1. Захиргааны байгууллагууд өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр харилцах, үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд:

1.1. Захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болох эрх зүйн үндсийг тодорхойлж өгөх;

1.2. Иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний жагсаалт, цахим үйлчилгээний хураамж тооцох аргачлалыг тогтоох, уг аргачлалд цахим үйлчилгээний өртөг, үнэ цэнийг тооцох, уг аргачлалд тулгуурлан төрийн цахим үйлчилгээний хураамжийг үйлчилгээ тус бүрээр тогтоох эрхийг захиргааны байгууллагуудад олгох зохицуулалтыг зааж өгөх;

1.3. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон зуучлах байгууллагын эрх зүйн байдал, эрхлэх үйл ажиллагааг тогтоох;

2. Төрийн цахим харилцааны суурь системийн эрх зүйн байдлыг тодорхойлох зорилтын хүрээнд:

2.1. Нийт захиргааны байгууллага хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй харилцах цахим харилцаанд нийтлэг, дундын байдлаар хувааж ашиглах төрийн цахим мэдээлэл солилцох үйл ажиллагаа, таньж нэвтрүүлэх үйл ажиллагаа (Single Sign on), цахим шуудан болон цахим баримт бичгийн солилцох үйл ажиллагаа, цахим архив, эргэн мэдээлэх үйл ажиллагаа, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал, иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааны эрх зүйн байдлыг тодорхойлох, тэдгээр үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;

2.2. Эдгээр системийн ашиглалтын журмыг Засгийн газраас батлахаар тусгах;

2.3. Төрийн цахим харилцааны талаарх захиргааны байгууллагуудын чиг үүрэг, тэдгээрийн эзэмшилд байгаа мэдээллийн сан, системийн эрх зүйн байдлыг тодорхойлох, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах шаардлагыг тодорхойлох;

2.4. Төрийн цахим харилцааны талаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхой болгох;

3. Төрийн мэдээллийн сангийн ашиглалтын хүрээнд

3.1. Төрийн мэдээллийн сангийн ангилал, суурь ба төрөлжсөн мэдээллийн сангийн эрх зүйн байдал, мэдээллийн санг бүрдүүлэх зарчмыг тодорхойлох;

3.2. Төрийн мэдээлэл, мэдээллийн сангийн мэдээллийг төрийн үйлчилгээ, төрийн эрх барих байгууллагын үйл ажиллагаа, нээлттэй өгөгдөл бий болгоход ашиглах зохицуулалт бий болгох;

3.3. Төрийн байгууллагууд өөр хоорондоо болон иргэн, хуулийн этгээд төрийн мэдээлэлд хандах эрх зүйн байдлыг тодорхойлох, уг хандалтыг хангах арга замыг тодорхойлох;

3.4. Төрийн нээлттэй өгөгдлийг ашиглах арга замыг тодорхойлох;

4. Цахим засгийн нэгдсэн удирдлага, төлөвлөлт, хяналтын тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.1. Төрийн цахим харилцааны тогтвортой, тасралтгүй байдлын нэгдсэн удирдлага, зохицуулалт, төлөвлөлтийг хангах чиг үүрэг бүхий Цахим засгийн бодлогын зөвлөлийг байгуулах, чиг үүргийг тодорхойлох;

4.2. Зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заах;

4.3. Захиргааны байгууллагын мэдээллийн технологийн бодлого, хөтөлбөр, мэдээллийн сан, систем, сүлжээ байгуулах болон шинэчлэх төсөл, түүний хөрөнгө оруулалтыг Зөвлөлийн Ажлын албаар хянуулж, баталгаажуулахаар тусгах;

4.4. Ажлын алба захиргааны байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн сан, систем, сүлжээний нэгдсэн бүртгэл хөтлөх, тэдгээрийг шинээр болон шинэчлэн хөгжүүлэх шаардлагыг хянах, баталгаажуулахаар тусгах;

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төрийн цахим харилцааны хууль батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна:

1. Иргэн, хуулийн этгээдийн хувьд. Төрийн үйлчилгээг өөрийн биеэр төрийн байгууллагад хандаж авахаас гадна төрийн үйлчилгээний зуучлагч байгааллагаар дамжуулан, эсвэл цахим хэлбэрээр авах тохиодолд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломжтой болно. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломж өргөжиж Үндсэн хуулиаар олгосон эрх, эрх чөлөөгөө баталгаажуулахаас гадна төрийн үйлчилгээг нэг цэгээс авах, төрийн үйлчилгээ авахтай холбоотой үүсч байсан санхүүгийн болон цаг хугацааны зардлын хэмнэлт эдлэх, төрийн үйлчилгээний талаархи сэтгэл ханамж дээшилнэ. Төрийн нээлттэй өгөгдлийн тусламжтай шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх, *олон нийтийн хүртээл болгох боломж* нээгдэнэ.

2. Төрийн байгууллагуудын хувьд. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж үйл ажиллагааны шинэчлэл, инноваци, мэдээллийн систем, тооцоолон бодох техник хэрэгслийн нөөцийн удирдлага, төлөвлөлт сайжирна. Төрийн мэдээллийн сан, системийн төлөвлөлт, үнэ цэнэ, чадавхи өсч хариуцлага, ил тод байдал дээшилнэ.

3. Монгол Улсын хувьд. Монгол Улсын хөгжлийн олон улсын түвшний үзүүлэлт, тухайлбал, НҮБ-аас гаргадаг засаглалын индекс, цахим засгийн хөгжлийн индекс, Транспаренси байгууллагаас гаргадаг авилгын индекс, Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлт сайжирч олон улсад эзлэх байр суурь, нэр хүнд өснө. Төрийн байгууллагуудын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулснаар төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд дахин инженерчлэлийг хэрэгжүүлж, удирдлагын шинэчлэл, мэдээлэлд суурилсан эдийн засгийн шинэ салбар үүсч хөгжих боломж нээгдэнэ. Төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж дээшилж төрд итгэх итгэл сайжирна.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Төрийн цахим харилцааны тухай хууль баталснаар Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, Бүртгэлийн ерөнхий хууль, Цахим гарын үсгийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулна.

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР